



ЧИНГИС ХААН
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН ХХК

СУДАЛГАА

№:ҮБС-004/001003/2025

САНТЯГО ЗАРЧМЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГА

2025 ОН



**ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САН**

САНТЯГО ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгаа №: ҮБС-004/001003/2025

Бэлтгэсэн: Чингис хаан Үндэсний Баялгийн сан ХХК

2025 он

АГУУЛГА

Сантьяго зарчимд нэгдэх нь: Чингис хаан Үндэсний баялгийн сангийн стратегийн алхам.....	3
1. Товч агуулга.....	3
2. Яагаад бид нэгдэх шаардлагатай вэ?	3
3. Үндсэн санал, зөвлөмж	4
4. Хураангуй дүгнэлт:.....	16

Сантьяго зарчимд нэгдэх нь: Чингис хаан Үндэсний баялгийн сангийн стратегийн алхам

1. Товч агуулга

Чингис Хаан Үндэсний Баялгийн Сан нь Монгол Улсын баялгийн сангийн тогтвортой, хариуцлагатай, олон улсын жишигт нийцсэн засаглал, удирдлагыг төлөвшүүлэх зорилгоор Олон улсын баялгийн сангуудын форум (IFSWF)-ын баталсан **Сантьяго зарчим**-ыг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг тодорхойлох зорилгоор судалгааг эхлүүлсэн бөгөөд ийнхүү судалснаар Баялгийн сангийн **засаглалын ил тод байдал, хөрөнгө оруулалтын хариуцлагатай зарчим, иргэдийн итгэлцлийг** нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой замын зураглал, шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлох боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Түүнээс гадна, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд МУ-ын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан 30 дугаар тогтоолын 1-д “Үндэсний баялгийн сангийн орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн засаглал, үйл ажиллагааг олон улсын засаглал зарчим, загварт нийцүүлэн үе шаттайгаар бэхжүүлэх”, 2-т “Ирээдүйн өв сангийн тухай хууль дахь сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгон Үндэсний баялгийн сангийн тухай хуульд тусгах чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, 2029 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан дагуу Үндэсний баялгийн сангийн засаглал, үйл ажиллагааг олон улсын засаглал зарчим, загварт нийцүүлэх ажлыг цаг алдахгүй эхлүүлэх шаардлагатай гэсэн саналтай байна.

2. Яагаад бид нэгдэх шаардлагатай вэ?

- **Олон улсын стандарт, зарчимд нийцүүлэх:** Сантьяго зарчим нь дэлхийн даяар тогтвортой үйл ажиллагаа явуулж буй 30 гаруй баялгийн сан засаглал, хөрөнгө удирдлага, гадаад итгэлцэл, дотоод хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд дагаж мөрддөг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдлага, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлогч суурь баримт бичиг юм.
- **Тогтвортой засаглал:** Монгол Улсын хувьд хэдийгээр Үндэсний баялгийн санг хуульчилан үүсгэн байгуулаад байгаа боловч Баялгийн сангийн дотоод зохион байгуулалт, удирдлагын бүтэц, хариуцлагын механизмыг тодорхой зохицуулаагүй өнөөгийн нөхцөлд олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд суурилсан засаглалын бүтэц, тогтолцоог бүрдүүлэх нь чухал.
- **Хөрөнгө оруулалтын үр өгөөж, эрсдэлийн удирдлагыг сайжруулах:** Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд одоогоор Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангийн хөрөнгө удирдлагын бодлого батлагдсан бөгөөд тэдгээр бодлогод заасан хөрөнгө оруулалтын зорилтот

өгөөжийн түвшин тодорхой бус, мөн эрсдэл үр өгөөжийн зохистой харьцаа, жишиг үзүүлэлт, бодлогын зааг хэмжээ тусгагдаагүй байна.

- **Гадаад итгэлцэл, дотоод хяналтыг нэмэгдүүлэх:** Сангийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, тогтмол тайлагнаж, гадаад болон дотоодын хөндлөнгийн аудитын тогтолцоог нэвтрүүлэх нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, олон нийтийн хяналтыг сайжруулах ач холбогдолтой.

3. Үндсэн санал, зөвлөмж

1. IFSWF-д гишүүнээр элсэх

- Сантьяго зарчмуудыг мөрдөж буйгаа нотолж, олон улсын үнэлгээ, харьцуулалт, чадавх бэхжүүлэлтэд хамрагдах боломжтой болно.

2. Засаглалын бүтэц, эрх мэдлийн хуваарилалт

- Сантьяго зарчимд нэгдсэн тохиолдолд Үндэсний баялгийн санг удирдах дээд байгууллага, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, удирдлагын бусад бүтэц, тэдгээрийн хариуцлагын сүлжээг тодорхой болгох хэрэгцээ шаардлага төдийгүй нөхцөл бүрдэнэ.

3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо бий болгох

- Сан бүрт (Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан) тохирсон эрсдэлийн үнэлгээ, аудит, хяналтын журам боловсруулж хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

4. Санхүүгийн ил тод байдал ба тайлагнал

- Үндэсний баялгийн сангийн удирдах дээд байгууллага нь сангийн санхүүгийн гүйцэтгэл, хөрөнгийн өгөөжийг улирал тутамд олон нийтэд нээлттэй байдлаар мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх үүргийг хүлээж, хэрэгжүүлнэ.

5. Гадаад хөрөнгө удирдлагын хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Олон улсын туршлагатай хөрөнгө удирдлагын байгууллагуудтай хамтран хөрөнгийн өгөөж, эрсдэлийн тэнцвэрийг хангах боломжийг эрэлхийлнэ.

Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаанд баримтлах зарчмуудын нэг болох олон улсын сайн туршлага, сайн засаглалыг бэхжүүлэх зарчмын хүрээнд International Forum of Sovereign Wealth Funds (IFSWF) болон бусад олон улсын санхүүгийн байгууллагын зүгээс хүлээн зөвшөөрч баримталдаг Сантьягогийн зарчмыг Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлага хэрэгжүүлэлтийн бэлтгэлийг хангах чиг үүрэгтэй Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК болон Ирээдүйн өв сан Корпорац, бусад төрөлжсөн сангуудын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, тогтвортой өсөлт бүхий сантай болох стратегийн зорилгыг бодит ажил хэрэг болгоход томоохон хөшүүрэг болох юм.

Сантьягогийн зарчмууд нь 2008 оноос хойш хэрэгжиж байгаа бөгөөд олон улсад амжилттай үйл ажиллагаа явуулж буй, хүлээн зөвшөөрөгдсөн ҮБС-гууд нь Олон улсын үндэсний баялгийн сангийн форум (International Forum of Sovereign Wealth Funds) гишүүн байдаг. Энэхүү форум нь 2009 онд байгууллагдаж, 30 гаруй улсын ҮБС-гийн гишүүнчлэлтэй бөгөөд гишүүн ҮБС-гууд нь Сантьягогийн зарчмуудыг мөрдөнө гэсэн шаардлагын дагуу сайн дураараа элсдэг. Гишүүн болсноор Баялгийн сангууд нь тогтмол Сантьягогийн зарчмыг хэрхэн хангаж ажиллаж буйгаа дүгнэж тайлагнадаг¹.

Зарчмуудыг хэрэгжүүлэхдээ 3 бүлэг агуулгаар авч үздэг.

- 1 дүгээр бүлэг: Хууль эрх зүйн орчин, зорилго болон макро-эдийн засгийн бодлогоор зохицуулах
- 2 дугаар бүлэг: Байгууллагын зохион байгуулалт болон засаглалын бүтэц
- 3 дугаар бүлэг: Хөрөнгө оруулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Монгол Улсын хувьд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталснаар Сантьягогийн зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн гэж үзэж болно.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль нь цаашид төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх, засаглалын бүтцийг тодорхойлох, нээлттэй ил тод байдлыг бэхжүүлэх харилцаанд баримтлах гол эрхзүйн зохицуулалт болох учраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгын хүрээнд зарчимтай уялдуулж, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүсч байна. Түүнчлэн Баялгийн сангийн хууль тогтоомжийг ил тод нээлттэй, иргэдэд ойлгомжтой болгож Сантьягогийн зарчимд бүрэн нийцүүлэхийг эрмэлзэн ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн, Үндэсний баялгийн сан нь Сантьяго зарчимд албан ёсны гишүүнээр элсэх нь бодлогын хүрээнд түлхэц үзүүлж, хууль тогтоомжийг зарчимд нийцүүлэх эрмэлзлийг нэмэгдүүлэх эхлэл болно гэж үзэж байна.

Иймд, дээрх 3 бүлэг агуулгаар Үндэсний баялгийн сангийн тухай хууль, тогтоомжид Сантьягогийн 24² зарчмыг тусгаж, хэрэгжүүлж буй байдалд дор дурдсан дүн шинжилгээг хийлээ.

¹ https://www.ifswf.org/sites/default/files/SantiagoP15CaseStudies1_0.pdf?utm_source=chatgpt.com

² https://www.ifswf.org/sites/default/files/santiagoprinciples_0_0.pdf

ҮБС-004/001003/2025

Сантьяго зарчмууд, үндсэн бүтэц	Зарчмууд	Зарчимд нэгдэх хэрэгцээ, шаардлага болон үндэсний баялгийн сангийн тухай хуульд зохицуулсан байдал	Цаашдын хэрэгцээ, шаардлага
Хууль эрх зүйн орчин, зорилго болон макро-эдийн засгийн бодлогоор зохицуулах	Зарчим 1: Баялгийн сангийн эрх зүйн орчин нь тодорхой бөгөөд сангийн үйл ажиллагаа үр дүнтэй ба зорилгодоо хүрэхэд дэмжлэг үзүүлэхүйц байх.	Баялгийн сан байгуулах эрх зүйн үндэслэл болох бүрэлдэхүүн хуулийг баталж, хэрэгжүүлсэн нь энэхүү зарчмыг дагаж мөрдөж, хэрэгжүүлж байгааг илтгэж байна.	Бүрэн хэрэгжүүлж байгаа гэж үзэж болно.
	Дэд зарчим 1.1. Баялгийн сангийн эрх зүйн орчин нь Баялгийн сангийн хуулийн зохицуулалт, үйл ажиллагааг эрхлэн явуулахад хангалттай байх.	Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бэлтгэлийг хангах чиг үүрэгтэй Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийн үйл ажиллагаа нь Компанийн тухай хуулиар зохицуулагдаж байна. Харин төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагыг нэгдсэн байдлаар хараат бусаар хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг тодорхойлох шаардлага байсаар байна.	Баялгийн сангийн хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх чиг үүргийг Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар зохицуулах
	Дэд зарчим 1.2. Төрөлжсөн сангуудын онцлог ялгаа, бүтэц, тэдгээрийн хоорондын болон бусад төрийн байгууллагатай харилцах харилцаа нь олон нийтэд ил тод байх	Үндэсний баялгийн сан нь 3 төрөлжсөн сангаас бүрдэхээр хуульчилсан. Тэдгээр 3 сангуудын ялгаа, бүтцийг тодорхойлж өгсөн боловч хоорондын уялдаа болон төрийн эрх бүхий байгууллагуудтай хэрхэн харилцах харилцааг бүрэн зохицуулаагүй.	Яамд болон Монголбанкны хоорондын харилцааг тодорхой болгох
	Зарчим 2: Баялгийн сангийн бодлого, зорилго нь ойлгомжтой тодорхойлогдсон байх, олон нийтэд ил тод нээлттэй байх	Баялгийн сангийн эрх зүйн үндэслэл нь Үндсэн хуулийн 6.2 дугаар хэсэгт тусгагдсанаар Үндэсний баялгийн сангийн бодлого зорилгын хувьд “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй	Бүрэн хэрэгжүүлж байгаа гэж үзэж болно.

		үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх” үндсэн зорилготой гэж хуульд тодорхойлсон.(ҮБСтХ – 1.1)	
	Зарчим 3: Баялгийн сангийн үйл ажиллагаа нь дотоодын макро эдийн засагт шууд нөлөөлөх тул баялгийн сангийн үйл ажиллагааг төсөв, мөнгөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас удирдан чиглүүлэх	Сангийн үйл ажиллагааг Засгийн газар нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах ба Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагууд боловсруулж, хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тайлагнах ба тайланг хянаж, удирдан чиглүүлэх чиг үүрэг нь Сангийн яаманд хадгалагдахаар заасан. (ҮБСтХ- 13.2)	Бүрэн хэрэгжүүлж байгаа гэж үзэж болно.
	Зарчим 4: Баялгийн сангийн эх үүсвэр, зарцуулалт, санхүүжилт болон зарцуулалтын үйл ажиллагаа нь урьдчилан тодорхойлогдсон нийтэд ил тод бодлого, дүрэм журмаар зохицуулагддаг байх	Баялгийн сангийн эх үүсвэрийг тооцож, төрөлжсөн санд төвлөрүүлэх аргачлалыг батлах. (ҮБСтХ – 8.1.4) Үндэсний баялгийн сан болон төрөлжсөн сантай холбоотой бүх эрхзүйн баримт бичиг нийтэд ил тод www.legalinfo.mn эрхзүйн мэдээллийн санд байршуулсан.	Бүрэн хэрэгжүүлж байгаа гэж үзэж болно.
	Дэд зарчим 4.1. Баялгийн сангийн санхүүжилтийн эх үүсвэр нь олон нийтэд нээлттэй байх	Иргэдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар мэдээллийг түгээх систем одоогоор байхгүй, хөгжүүлэх шаардлагатай.	Систем хөгжүүлэх шаардлагатай.
	Дэд зарчим 4.2. Баялгийн сангаас зарцуулалт хийх ерөнхий чиглэл болон Засгийн газар иргэдийн нэрийн өмнөөс зарцуулалт хийх журам нийтэд ил тод байх	Хуримтлалын сангийн зарцуулалтын журам, бодлого батлагдсан. Хөгжлийн сангийн зарцуулалтыг тодорхой болгох шаардлага байна.	Хөгжлийн сангийн зарцуулалт, Хөгжлийн төслийг шалгаруулах журмыг батлах.
	Зарчим 5: Баялгийн сангийн статистик тоон мэдээллийг цаг тухай бүрд, шаардлагатай бол зохих макро эдийн засгийн үзүүлэлтийн хамт өмчлөгчид тайлагнадаг байх	Ирээдүйн өв сангийн тухай хуулиар тус сангийн удирдлагын тайланг жил бүр 1 удаа, хөрөнгө удирдлагын тайланг сар бүр тайлагнадаг байх зохицуулалтыг тусгасан.	Батлагдсан хууль тогтоомжийн

		Хуримтлалын сангийн хувьд Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас жил бүр тайлагнахаар зохицуулсан. Хөгжлийн сангийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахыг хуульчилсан. (ҮБСтХ - 8.3.2)	зохицуулалтыг сайжруулах.
Байгууллагын бүтэц болон засаглалын бүтэц	Зарчим 6: Баялгийн сангийн засаглалын тогтолцоо, хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг тавьсан зорилгодоо хүрэхэд нь бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулахын тулд нэгжийн үүрэг, хариуцлагын тогтолцоо ойлгомжтой, үр ашигтайгаар зохион байгуулагдсан байх	- Үндэсний баялгийн сан нь засаглалын хувьд Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн охин компани; - Засаглал бүтэц, тогтолцоог хуульчлаагүй; - Ирээдүйн өв сан корпорацийн засаглал тогтолцоог 2030 оноос хэрэгжүүлэх зохицуулалттай; - Хуримтлалын сан, Хөгжлийн сан засаглалын бүтцийн талаар тусгайлсан зохицуулалт одоогоор байхгүй.	Үндэсний баялгийн сангийн засаглалын тогтолцоо, бүтцийг зөв тодорхойлох, сангуудын үйл ажиллагаатай уялдуулах хэрэгцээ, шаардлага байна.
	Зарчим 7: Баялгийн сангийн өмчлөгч нь баялгийн сангийн зорилго, зорилтыг тодорхойлж, урьдчилсан тогтоосон процедурын дагуу Сангийн удирдах дээд байгууллагыг томилох, үйл ажиллагаанд хяналт тавих	Үндэсний баялгийн сангийн тухай хуульд сангийн үйл ажиллагааны удирдлага хэрэгжүүлэгч нь Төрийн захиргааны төв байгууллага буюу Яамд байхаар заасан. Сангийн зорилгод нийцсэн мэргэжлийн менежментийн багийг томилоогүйгээс хөрөнгө удирдлагын өгөөжийн түвшин иргэдийн хүлээлтэд хүрэхгүй, ил тод байдал хангагдахгүй зэрэг асуудлууд тулгарч байна.	Сангийн удирдах дээд байгууллага, түүний статусыг хуульд тодорхойлж, хуулийн хэрэгжилтийг хангах

	Зарчим 8: Баялгийн сангийн дээд удирдах байгууллага нь Баялгийн сангийн эрх ашгийн төлөө сонирхлын зөрчилгүй үйл ажиллагаа явуулах ба энэхүү үүргээ биелүүлэхийн тулд хөрөнгийн удирдлагын мандат тодорхой, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хангалттай бүрэн эрх, эрх мэдэлтэй байх.	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хувьд Мандатын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй. Баялгийн сангийн хөрөнгө удирдлагыг голлон хэрэгжүүлэгч нь Монголбанк. Монголбанк нь Сантъяго зарчимд заасан ашиг сонирхлын зөрчилгүй этгээд гэж үзэх боломжгүй, мөнгөний бодлого тодорхойлж, зохицуулагч субъект. Гэтэл Үндэсний баялгийн сангийн зорилго нь баялгийн удирдлагыг урт хугацаандаа, үр ашигтай хэрэгжүүлэх буюу Сангийн бодлоготой илүү уялдаа холбоотой байна.	Монголбанк гадаад хамтын ажиллагааны хязгаарлагдмал хүрээнд хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлж байна.
	Зарчим 9: Баялгийн сангийн үйл ажиллагааны удирдлага нь баялгийн сангийн стратегийг бие даасан байдлаар, урьдчилан тодорхойлсон чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлдэг байх	Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бэлтгэлийг хангах чиг үүрэгтэй Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийн зүгээс Монголбанк Сангийн яамтай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлж буй хөрөнгө удирдлагын шийдвэрт нөлөөлөх эрх зүйн үндэслэл, боломж байхгүй.	Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын стратеги тодорхой болгох
	Зарчим 10: Баялгийн сангийн үйл ажиллагааны хариуцлагын тогтолцоо нь холбогдох хууль, дүрэм, хөрөнгийн удирдлагын гэрээнд тодорхой тусгагдсан байх	Баялгийн сангийн үйл ажиллааны удирдлагыг хуульд зааснаар Яамд хэрэгжүүлж байгаа бөгөөд үйл ажиллагааны удирдлага хэрэгжүүлэхтэй холбоотой хариуцлагын тогтолцоог бүрэн тодорхойлоогүй.	Нэмэлтээр зохицуулах шаардлагатай.
	Зарчим 11: Баялгийн сангийн жилийн тайлан, санхүүгийн нь олон улсад ба дотоодод хүлээн зөвшөөрсөн Нягтлан бодох бүртгэлийн стандартад зааснаар төлөвлөсөн хугацаандаа гардаг байх	Төрийн захиргааны төв байгууллага, нь хариуцсан төрөлжсөн сангийн үйл ажиллагааны удирдлага нь сангийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. (ҮБСтХ – 13.2)	Одоогоор Ирээдүйн өв санд төвлөрч буй эх үүсвэрийн мэдээлэл сар бүр гарч байна.
	Зарчим 12: Баялгийн сангийн үйл ажиллагаа ба санхүүгийн тайлангууд нь жил бүр олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн	Төрөлжсөн сангийн жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана. (ҮБСтХ - 14.3)	Төрийн аудитаас гадна олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын

	зөвшөөрөгдсөн стандартын дагуу аудит хийгддэг байх		фирмүүдийг ажиллуулах зохицуулалтыг тусгах шаардлагатай.
	Зарчим 13: Мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээ нь ойлгомжтой тодорхойлогдсон, Баялгийн сангийн удирдах байгууллага болон ажилтнуудын бүх түвшинд хэрэгжүүлдэг байх	Мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг батлах шаардлагатай ба ажилтнууд нь нууцлал бүхий мэдээллийг боловсруулж байгаа тул байнгын давтан сургалтыг зохион байгуулах.	Нууцлал алдагдаж ёс зүйн зөрчил гарснаар улсын эрх ашиг хөндөгдөх тул хуулиар зохицуулах шаардлагатай.
	Зарчим 14: Баялгийн сангийн үйл ажиллагааг удирдан явуулах зорилгоор гуравдагч этгээдтэй харилцах харилцаа нь зөвхөн эдийн засгийн болон санхүүгийн зорилгод суурилсан, цаашлаад дүрэм, журам нь тодорхой байх	Үндэсний баялгийн сангийн тухай хуульд баялгийн сангийн үйл ажиллагааны удирдлага хэрэгжүүлэх зорилгоор харилцах харилцааг зохицуулаагүй боловч Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК нь баялгийн сангийн үйл ажиллагааг гадаад, дотоодод сурталчлан таниулах чиг үүргийн хүрээнд гадаад, дотоодын зөвлөхүүдтэй хамтын ажиллагааг эхлүүлэх шаардлага үүсэж байна. Иймд Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК нь энэхүү асуудлаар дотоод дүрэм, журмыг батлах хэрэгцээ үүсээд байна.	Гадаад, дотоодод сурталчлан таниулах зорилгоор гадаад зөвлөх сонгон шалгаруулах хэрэгцээ байна.
	Зарчим 15: Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг явуулж буй улс орнуудын зохицуулалт, мэдээллийн ил тод байдлын бүхий л шаардлагыг баялгийн сан хангаж ажилладаг байх	Монголбанкнаас одоогоор ирээдүйн өв сангийн хөрөнгийг зарим улсын банкинд богино хугацаатай хадгалуулж байгаа ч Баялгийн сангийн зүгээс хөрөнгө удирдлагын үйл ажиллагааг явуулж буй улсын зохицуулалтад нийцүүлсэн гэж шууд дүгнэх боломжгүй. Монголбанк хадгаламжид байршуулж буй улсуудыг хэрхэн тодорхойлж байгаа нь ойлгомжгүй.	Хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлж эхэлсэнд тооцогдож болох ч тэдгээр улсын хууль тогтоомжийг судалсан байх,

			удирдаж буй хөрөнгийн өгөөж нь хуульд заасан өгөөжийн түвшинд хүрч байгаа эсэхийг тооцож үр ашгийг тодорхойлох.
	Зарчим 16: Баялгийн сангийн засаглалын бүтэц, зорилго хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг бие даасан байдлыг хангахуйц, өмчлөгчөөс хараат бус, олон нийтэд ил тод байх	Үндэсний баялгийн сан дахь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгө удирдлагын үйл ажиллагааг гэрээгээр Монголбанк хэрэгжүүлж байна. Харин Үндэсний баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бэлтгэлийг хангах чиг үүрэг бүхий Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК нь орлого төвлөрүүлэгч төрийн өмчит компанийн охин компани хэлбэрээр байгуулагдсан төдийгүй 100% зээлийн санхүүжилтээр санхүүждэг, хараат байдалтай байна	Хараат бус, бие даасан засаглал тогтолцоог хуульчлан тодорхойлох шаардлагатай.
	Зарчим 17: Баялгийн сантай холбоотой санхүүгийн мэдээллийг олон нийтэд танилцуулж, эдийн засаг, санхүүгийн чиг баримжааг харуулж, хөрөнгө удирдлагын үйл ажиллагааг явуулж буй улс орны итгэлцлийг нэмэгдүүлдэг байх	Төрөлжсөн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг хөндлөнгийн аудитын дүгнэлт гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор Засгийн газраас олон нийтэд мэдээлнэ. (ҮБСтХ – 14.1) Олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Үндэсний аудитаас бие даасан, хөндлөгийн аудитаар дүгнэлт гаргуулж болно.	Жилд нэг удаа аудитын дүгнэлттэй тайлагнахаас илүү ил тод, ойлгомжтой байдлыг иргэдийн хүлээлтэд нийцүүлж мэдээллийн урсгалын давтамжийг нэмэгдүүлэх

Хөрөнгө оруулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо	Зарчим 18: Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлого нь багцын зохистой удирдлагын зарчимд суурилсан, зорилго бүхий, хөрөнгө оруулалтын стратеги, эрсдэлийн түвшинд бүрэн тодорхойлогдсон байх	Үндэсний баялгийн сангийн тухай хуульд зааснаар хөрөнгө удирдлагын бодлогыг Сангийн яам боловсруулж, батлуулна. Хөрөнгө оруулалтын стратеги, багцын эрсдэлийн түвшинг бүрэн тогтоогоогүй байна.	Хөгжлийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого батлагдаагүй.
	Дэд зарчим 18.1. Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого нь баялгийн сангийн санхүүгийн эрсдэлийн түвшин болон үр өгөөжийн хөшүүргийг хэрэглэх боломжийг тусгасан байх	Ирээдүйн өв сангийн эх үүсвэрийг арвижуулах хөрөнгө удирдлагын бодлогод, эрсдэлийн зохистой түвшинд авч болох хамгийн өндөр зорилтот өгөөжийн хувь, түүний зохицуулалтын талаар тодорхой тусгаагүй байна. Хуримтлалын сангийн зорилтот өгөөжийн доод түвшинг бодлогын хүүтэй уясан нь учир дутагдалтай. Хуримтлалын сан нь 3 төрлийн зарцуулалттай бөгөөд тухайн зарцуулалтын өсөлт, зарцуулалт хийх эрх үүсэхэд шаардагдах хугацаа зэрэг нь хуримтлалын сангийн зорилтот өгөөжийн түвшин, хөрвөх чадвар болон хөрөнгө оруулалтын хугацааны шийдвэр гаргалтад хамгийн ихээр нөлөөлнө. Хэрвээ хуримтлалын сангийн өгөөж нь зарцуулалтын өсөлтөөс тогтмол бага байх тохиолдолд иргэд аль болох хурдан зарцуулалт хийх, цаашлаад сангийн хөрвөх чадвар болон тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө.	Өгөөжийг тооцоолох аргачлалыг боловсронгуй болгож хөрөнгө удирдлагын бодлогод тусгаж, өөрчлөх
	Дэд зарчим 18.2. Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого нь дотоод болон гадаад хөрөнгө оруулалтын менежерүүдэд зориулагдсан байх ба тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ, эрх хэмжээ, тэдгээрийг сонгох, гүйцэтгэлд хяналт тавих журмыг тодорхойлсон байх	Ирээдүйн өв сангийн хөрөнгө удирдлагын бодлогын 3.4 дүгээр зүйлд “Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын санхүүгийн байгууллага, эсхүл хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг, гадаадын мэргэшсэн хуулийн этгээдээр энэхүү бодлогын хүрээнд гэрээ	Гадаад хөрөнгө оруулалтын менежер ажиллуулах хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны цар хүрээ, эрх

		байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэж зохицуулсан боловч энэхүү заалтыг одоогоор бодитоор хэрэгжүүлж эхлээгүй байна.	хэмжээ, гүйцэтгэлд хяналт тавих журмыг тодорхойлох.
<i>Дэд зарчим 18.3.</i> Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого нь нийтэд ил тод байх		Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлого нийтэд ил тод байршсан байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355959684341	Бүрэн хэрэгжүүлж байгаа гэж үзэж болно.
Зарчим 19: Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын шийдвэр нь хөрөнгө удирдлагын бодлогын дагуу, санхүү эдийн засгийн тооцоолол бүхий, эрсдэлээр жигнэгдсэн өгөөжийг хамгийн их байлгахад чиглэдэг байх		Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлого нийтэд ил тод байршсан байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355959684341 Хөрөнгө удирдлагын бодлого батлагдсан ч өгөөжийг хамгийн их байхад чиглэсэн гэж дүгнэх боломжгүй. Одоо байгаа бодлогын хүү, эсвэл Засгийн газрын бондын эрсдэлгүй хүүгээр хуримтлалын сангийн өгөөжийн түвшинг тогтоож өгөх нь буруу.	Сангийн өгөөжийн түвшин нь зарцуулалтын хурдтай уялдуулах нь зүйтэй.
<i>Дэд зарчим 19.1.</i> Хэрвээ баялгийн сангийн хөрөнгө удирдлагын шийдвэр нь санхүү, эдийн засгийн шинжилгээнээс өөр үндэслэлтэй бол хөрөнгө удирдлагын бодлогод тусгагдсан, олон нийтэд ил тод байх		Эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлаас өөр бусад үндэслэлээр хөрөнгө оруулахгүй байх шаардлагатай. Аливаа үндэслэл нь хөрөнгө удирдлагын бодлогод тусгагдсан байх шаардлагатай.	Хөрөнгө удирдлагын бодлогыг нэмж сайжруулж, үндэслэлгүй зарцуулалтын нөхцөлийг хязгаарлах шаардлагатай.
<i>Дэд зарчим 19.2.</i> Баялгийн сангийн хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэгч нь нийтээр хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн удирдлагын зарчмуудтай нийцсэн, тогтвортой байх.		Сангийн хөрөнгийг найдвартай, хөрвөх чадвартай байх нөхцөлийг зэрэг хангасны үндсэн дээр эрсдэл-өгөөжийн зохистой түвшнийг баримтлан удирдах – Ирээдүйн өв сангийн Хөрөнгө удирдлагын бодлого 2.2, ҮБСтХ 5 дугаар зүйлд тусгагдсан.	Хөрөнгө удирдлагын бодлого баталж хэлбэрийн хувьд нийцүүлсэн ч хөрөнгө

			удирдлага хэрэгжүүлэгчийн тогтвортой байдлыг бэхжүүлэх шаардлагатай.
	Зарчим 20: Баялгийн сан нь хувийн хэвшилтэй өрсөлдөхдөө давуу эрхээр, эсвэл засгийн газрын зохисгүй нөлөөллөөр мэдээлэл олж авахгүй байх, тийм давуу талыг эрэлхийлэхгүй байх	Үндэсний баялгийн сан нь Засгийн газраар дамжуулан хувийн хэвшилтэй өрсөлдөх, зохисгүй нөлөөлөл үзүүлэх, давуу эрх олгосон зохицуулалт байхгүй боловч хязгаарласан заалт байхгүй.	Хязгаарласан зохицуулалт шаардлагатай.
	Зарчим 21: Баялгийн сан нь хувьцааны саналын эрхийг хөрөнгийн удирдлагын салшгүй хэсэг гэж үзнэ. Хэрэв баялгийн сан нь хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхээр шийдсэн бол хөрөнгө удирдлагын бодлогод нийцүүлж, хөрөнгө оруулалтынхаа өгөөжийн үнэ цэнийг хамгаалах аргаар хэрэгжүүлнэ. Баялгийн сан нь хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхдээ биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн үнэт цаасны санал өгөх ерөнхий аргыг үндэслэл болгож, олон нийтэд нээлттэй зарласан байна.	Тодорхой зохицуулалт байхгүй.	Энэ талаар зохицуулах шаардлагатай.
	Зарчим 22: Баялгийн сан нь сангийн үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах суурь тогтолцоотой байх	Тодорхой зохицуулалт байхгүй.	Энэ талаар зохицуулах шаардлагатай.

	Дэд зарчим 22.1. Баялгийн сангийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь тодорхой хүлээн зөвшөөрөгдөх түвшний дотор эрсдэлийг удирдах, хянах, хяналт урамшууллын тогтолцоо, ёс зүйн дүрэм, бизнесийн тасралтгүй байх төлөвлөгөө, бие даасан аудитын үүргийг хангахуйцаар баталгаатай мэдээлэл дээр суурилан, цаг тухай бүр тайлан гаргадаг байх.	Тодорхой зохицуулалт байхгүй.	Энэ талаар зохицуулах шаардлагатай.
	Дэд зарчим 22.2. Баялгийн сангийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь нийтэд ил тод байх	Тодорхой зохицуулалт байхгүй.	Энэ талаар зохицуулах шаардлагатай.
	Зарчим 23: Урьдчилан тодорхойлсон стандарт, зарчмуудын дагуу баялгийн сангийн хөрөнгө удирдлагын гүйцэтгэлийг хэмжиж, өмчлөгчид тайлагнадаг байх	Үндэсний баялгийн сан болон түүний төрөлжсөн сангууд нь Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн болохын хувьд хөрөнгийн гүйцэтгэл нь жил бүр тооцоологдож, тайлагнаж байна. Ирээдүйн өв сангийн хөрөнгийн гүйцэтгэл нь Сангийн яамны төсвийн гүйцэтгэл тайланд тусгагддаг.	Тодорхой түвшинд хэрэгжүүлж байна.
	Зарчим 24: Баялгийн сан Сантьяго зарчмуудын хэрэгжүүлж буй эсэх талаар тогтмол дүгнэлт гаргадаг байх	Одоогоор энэхүү зарчмыг заавал биелүүлэх үүрэг хүлээгээгүй тул хяналтыг хийх талаар дүгнэх боломжгүй.	Гишүүнчлэлтэй болсноор албан ёсны дүгнэлт гарах нөхцөл бүрдэнэ.

4. Хураангуй дүгнэлт:

- 1 дүгээр бүлэг:
 - Хууль эрх зүйн орчин, зорилго болон макро-эдийн засгийн бодлогоор зохицуулах хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулинд Баялгийн сангийн суурь зарчмыг тодорхойлж, Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн үйлдэл нь GAPP хамгийн эхний баялгийн санг хуульчлан зохицуулсан байх ерөнхий шаардлагыг хангаж, хэрэгжүүлж байгаа гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.
 - Макро эдийн засгийн бодлоготой уялдуулж Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар 3 төрөлжсөн санг тодорхойлж, сан тус бүрийн төрөл, зорилго, зориулалт, эх үүсвэр, зарцуулалтын асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулсан байгаа нь Баялгийн сангийн зорилго нь эрх зүйн зохицуулалтын хүрээнд харьцангуй ойлгомжтой тодорхойлсон бөгөөд Ирээдүйн өв сангийн хөрөнгийг гадаад зах зээлд хөрөнгө оруулах, харин Хуримтлалын сангийн эх үүсвэрийг дотоодын зах зээлд санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулахаар заасан байгаа нь Макро-эдийн засгийн бодлоготой уялдуулж баялгийн сангийн зорилгыг тодорхойлсон гэж үзэхээр байна.
- 2 дугаар бүлэг:
 - Үндэсний баялгийн сангийн хууль, тогтоомжид Үндэсний баялгийн сангийн эрх барих дээд байгууллагыг тодорхойлж өгөөгүй ба хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Баялгийн сангийн хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийг байгуулсан. Өөрөөр хэлбэл, Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК нь хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж ажиллаж байгаа тул Төрөлжсөн сангууд болон тус компанийн үйл ажиллагааны уялдааг хангах шаардлагатай.
 - Баялгийн сан байгууллагын зохион байгуулалтын хувьд Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компанийн статустай, засаглал, компанийн бүтэц, санхүүжилтийн хувьд орлого төвлөрүүлэгч аж ахуйн нэгжээс бүрэн хараат байдалтай байна.
 - Баялгийн сангийн Засаглалын бүтцийн хувьд Баялгийн санг удирдах дээд байгууллагыг тодорхойлоогүй, үйл ажиллагааны удирдлага хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны төв байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулж, бодлогын хэрэгжилтийг ил тод болгох шаардлагатай байна.

- Ирээдүйн өв сангаас бусад 2 төрөлжсөн сангийн хувьд сангийн засаглал, удирдлагад Сантьяагогийн зарчим үйлчилж байгаа эсэх нь тодорхой бус, ил тод нээлттэй байдал, олон нийтийн хяналтыг ямар хэмжээнд байлгах асуудлыг тодруулах зайлшгүй шаардлага үүсгэж байна.
- 3 дугаар бүлэг:
 - Хөрөнгө оруулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд одоогоор Сангийн яамнаас Ирээдүйн өв сан болон Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг баталсан, бодлогын хэрэгжилтийг одоогоор дүгнэх боломжгүй байна.
 - Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зохицуулалт одоогоор байхгүй, зайлшгүй зохицуулах хэрэгцээ, шаардлага байна. Сангийн хөрөнгийг хамгаалах, улс төр, хууль эрх зүйн болон макро эдийн засгийн эрсдлээс урьдчилан сэргийлж, сангийн үйл ажиллагааг тогтворжуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага байна.